

“Эрдэнэс сольюшинс” ХК

КОМПАНИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. АГУУЛГА

1. АГУУЛГА.....	2
2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
3. КОМПАНИЙН ТУХАЙ	4
1. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас.....	4
2. Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, регистрийн дугаар, бүртгэсэн огноо, сар, өдөр 4 айн зах зээлд эзэлж буй	4
4. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтаны цалин урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл	16
5. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компанийн талаарх мэдээлэл, хяналтын багц, ҮЦЗЗТХ-ийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээдүүдийнх нь тухай мэдээлэл	17
6. Компанийн сүүлийн 1 жилийн хугацаанд бусадтай байгуулсан гэрээ хэлцэл, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэлийн талаар.....	18
7. Компанийн ноогдол ашгийн талаар	19
8. Охин компаниудын тухай	19
9. Худалдан авсан охин компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.....	20
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц болон хуралдаанаар 2021 онд хэлэлцсэн асуудлууд	21

2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
ЗГ	Засгийн газар
КТХ	Компанийн тухай хууль
МУ	Монгол Улс
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
НА	Ногдол ашиг
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК
ҮЦБЖ	Үнэт цаасны бүртгэлийн журам
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХК	Хувьцаат компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЭЭБХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн их сургууль
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
СЭЗДС	Санхүү эдийн засгийн дээд сургууль

3. КОМПАНИЙН ТУХАЙ

1. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас

Компанийн нэр: “Эрдэнэ сольюшинс” Хувьцаат Компани

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 40 50 мянгат /15171/
Бакула ринбучийн гудамж 30 байр, 10-р давхар

2. Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, регистрийн дугаар, бүртгэсэн огноо, сар, өдөр

Компанийн нэр:	“Эрдэнэ сольюшинс” ХК
Үүсгэн байгуулагдсан огноо:	1996.04.20
Улсын бүртгэлийн дугаар:	9010001131
Регистрийн дугаар:	2015358
Үйл ажиллагааны чиглэл:	<ul style="list-style-type: none">- Програм хангамжийн үйл ажиллагаан /код-62010/- Програм хангамж, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа /код-47410/- Вэб сайт хийх /код-63120/- Мэдээлэлийн технологийн үйл ажиллагаа /код-63990/- Худалдааны зуучлал /код- 46100/
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	191 хувьцаа эзэмшигчидтэй. /2021 оны 03-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар тархалтын судалгаа/
Монголын хөрөнгийн биржийн хувьцааны арилжааны ангилал:	Үнэт цаасны бүртгэлийн III-р ангилал

3. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Компани 2020 онд “Эрдэнэ сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж технологийн чиглэлд үйл ажиллагаа эрхлэх болсоноор дараах бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйл ажиллагаагаа дараах компанийн хувьцааг худалдан авч өргөжүүлсэн болно.

Компанийн ТУЗ-ын 2021 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор компани СЗХ-ны гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөл бүхий “Эйс ассошиэйтс ББСБ”-ын 85%-ийг худалдан авах, СЗХ-ны үнэт металлын арилжааны “Эрдэнэ коммодитийс трейдинг” ХХК-ийн 90%-ийг худалдан авахаар шийдвэрлэсэн.

Үүнээс “Эйс ассошиэйтс” ББСБ-ын 85%-ийг 2021 оны 01-р сард сард худалдан авч, худалдан авахыг зөвшөөрсөн СЗХ-ны зөвшөөрөл гарсан. Энэ ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг 2021 онд нэмэгдүүлэн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авах болно. Гар утас ашиглан онлайн зээл олгох үйл ажиллагааг 2022 оны 2-р улиралд эхлүүлнэ.

Компани гадаад валютын арилжааны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор 2019 онд “Эрдэнэс капитал маркетс” ХХК үүсгэн байгуулсан. Компанийн програм хангамж, системийг хөгжүүлж байна. Компанийн програм хангамж, системийг хөгжүүлж байна.


Компанийн ТУЗ-ын 2021 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор хаа, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор “Эрдэнэс агро энд ресортс” ХХК-ийг үүсгэн байгуулсан. Үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн технологийн шийдэлийг нэвтрүүлж 2021 оны 4-р улиралд үйл ажиллагааг эхлүүлнэ.

“Хар хорум пропертийс” ХК нь үл хөдлөх хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд ТУЗ-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗТ 06/2020 тоот тогтоолоор “Эрдэнэс рийс эстэйт” ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагааг тусгаарласан. СЗХ-ны 2020 оны тоот ТЗ 601/54 тогтоолоор үл хөдлөх хөрөнгийн зуучлалын тусгай зөвшөөрөл авсан.





Үл хөдлөх хөрөнгө бүртгэлийн програм хангамж, платформыг хөгжүүлж байгаа бөгөөд 2022 оны 1-р улиралд ажилуулахаар төлөвлөж байна.

Эрдэнэс сольюшинс ХК-ний бүтэц зохион байгуулалт

Компани нь 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:



Компанийн хөгжүүлсэн програм хангамж

№	ПРОГРАМХАНГАМЖИЙН НЭР	АЖЛЫН ЯВЦ	ДУУСАСАН ХУТАЦАА	ХЭНД
1	Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны систем		2019 оны 2-р ул.	Ариг банк
2	Сууц өмчлөгчдийн холбооны мобайл апп		2020 оны 1-р ул.	Хангал систем ХХК
3	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын вэб		2020 оны 3-р ул.	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар
4	Дотоод бүртгэлийн систем		2021 оны 2-р ул.	Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

Компанийн бүтээгдэхүүн, хөгжүүлж буй төсөл

D³ARS систем

Энэ систем нь хувьцаат компани, хөрөнгө оруулалтын сангууд болон койн гаргагч эрх бүхий этгээдүүдийн нийтэд мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг мэдүүлэх, **цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах буюу** англиар **the Digital Data Disclosure, Analysis and Retrieval System** болон **the Digital Data Gathering, Analysis, and Retrieval System** гэх үгнүүдийн эхний үсгүүдийн нийлбэр, оюуны өмч бүхий D³ARS системийг 2019 оноос хойш хөгжүүлж дуусгаад байна. D³ARS систем нь мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдийн тухай бүр мэдүүлж буй мэдээллийг огноо болон цагаар бүртгэж, мэдүүлсэн мэдээллийг мэдээллийн санд цуглуулан, цугларсан мэдээллийг интернетээр дамжуулан олон нийтэд чөлөөтэй хүргэх боломжтой систем юм. Тухайлбал Монголын хөрөнгийн бирж болон бусад санхүү, бараа таваарын арилжааны биржид оролцогч олон нийтийн компаниуд, бусад үнэт цаас гаргагчид болон оролцогч байгууллагууд хууль, төрийн эрх бүхий байгууллагын журмаар шаардсан мэдээллийг /дата өгөгдөл/ мэдүүлэг гаргах замаар заавал бүрдүүлэх, мэдээллийг тогтсон маягтын дагуу системд оруулах замаар цуглуулж, баталгаажуулах, индексжүүлэх, хүлээн авах, дамжуулах, хайх ажлыг энэ систем гүйцэтгэнэ.

D³ARS системийн өгөгдлийн сангийн хөгжүүлэлт банк болон санхүүгийн байгууллагуудын ашиглаж эхлээгүй байгаа **Oracle 21c version** дээр хөгжүүлэгдсэн тул блокчэйнтэй технологи ашиглах, өгөгдлийн тандалт хийх боломжтой, веб технологид суурилсан тул олон нийтэд мэдээлэх болон хэрэглэгчийн олон ялгаатай эрхээр хандах боломж бүрдсэн, бусад системтэй холболт API-тай тул төрийн болон хувийн хэвшлийн системүүдтэй мэдээлэл солилцох бүрэн боломжтой, **XBRL** ашигладаг тул олон улсын бизнесийн мэдээлэл солилцох стандарттай олон хэлээр нийтлэгдэх боломжтой бөгөөд компани одоогоор Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг хуульд нийцэж буй эсэхэд хянах хиймэл оюун ухаан дээр ажиллаж байна.

D³ARS систем нь АНУ-д EDGAR of the US Form 8-K, Form 10-K, Form 10-Q, Form S-1, Канадад Sedar, Англид [Companies House](#), Япон улсад EDINET, БНСУ-д DART гэх мэтээр хөгжүүлсэн систем мэдүүлсэн үнэт цаас гаргагчдын мэдүүлгийг /Filing/ хөрөнгө оруулагчид ашиглан хөрөнгө оруулах эсэх шийдвэрээ гаргадаг системтэй ижил түвшинтэй ижил хэмжээнд хөгжүүлсэн систем юм.

D³ARS систем нь үнэт цаас гаргачид болон бусад зохицуулалттай этгээдүүдийн нийтэд мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн “9 дүгээр

зүйл.Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх” хэсгийн “79.2.3.тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.”, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06-р сарын 11-ний өдрийн Дугаар 225 тоот “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын “АРАВ. Үнэт цаас гаргагчийн тогтоосон хугацаанд болон тухай бүр ирүүлэх мэдээллийн төрөл, мэдээлэх хэлбэр,” Монголын хөрөнгийн бирж нь үнэт цаас гаргагчдын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох, тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх ажлын хүрээнд "Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"-тай бүрэн нийцэж байна.

D³ARS системийн хийж гүйцэтгэх ажлууд:

Хувьцаат компаниудын хувьцаагаа халааслах, сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх, эцсийн өмчлөгчийн мэдүүлэг, үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээлэл, эрх бүхий албан тушаалтануудын хамаарал, эзэмшил, Хорооны хяналт тавих зэрэг нийт 32 мэдүүлгээр компаниудыг мэдээллийг ил болгоно. Тухайлбал:

- Компанийн хувьцаа эзэмшигчдэд хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг тайлагнах;
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны тайлангуудыг тайлагнах;
- Компанийн сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлүүдийг тайлагнах;
- Компанийн 5 хувиас дээш болон хяналтын хувьцааг эзэмшигчдийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагчаас тухай бүр мэдээлэх мэдээлэл гэдэгт хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчаас шийдвэр гаргахад шаардлагатай компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллүүдийг тайлагнах;
- Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээллийг тайлагнах;
- Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээллийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийгбусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэлийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн

хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг тайлагнах;

- Компани хувьцаа болон бондыг олон нийтэд гаргаж буй үнэт цаасны танилцуулга зэргийг тодорхой маягтын дагуу харуулах.
- Хөрөнгө оруулагчид Мэдээллийн сангийн хайлтыг компанийн нэр, салбарын бүлэг, баримт бичгийн төрөл эсвэл гаргасан огноогоор хайж болох боломжтой.

D³ARS системийн ач холбогдол:

Олон тооны компанийн мэдүүлгийг багтаасан D³ARS систем нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, нийтэд мэдүүлэх үүрэг бүхий мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, мэдээлэл хүргэх процессийг хялбаршуулж, олон нийтэд түргэн шуурхай хүргэх боломжийг бий болгон, үнэт цаасны зах зээлийн үр ашиг, ил тод байдал, компаниудын шударга байдлыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулагчид, компаниуд болон Монгол улсын эдийн засагт үр өгөөжөө өгнө.

Нээлттэй компаниуд санхүүгийн болон бусад чухал мэдээллүүдийг тогтмол, цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж байх ёстой бөгөөд хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн менежерүүд, хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд болон бусад зах зээлд оролцогчдоос мэдлэг, мэдээлэлтэй байдлаар хэзээ, ямар компанид хөрөнгө оруулах болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад энэ систем ихээхэн ач холбогдолтой.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, цаашдын буруутай үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдыг хамгаалахад системийн ач холбогдол өндөр юм. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Брокерсмн систем

Арилжаа хийх “Брокерсмн” системийн танилцуулга

Хөрөнгийн зах зээлд оролцогч брокерийн компаниуд, тэдгээрийн харилцагчидад үнэт цаасны арилжааны эскроу данс нээхэд иргэд өөрийн биетээр цаг хугацаа, зардал гаргалгүйгээр данс нээх, үнэт цаасны арилжаанд оролцох, брокерийн компаниуд харилцагчдадаа чанартай хурдан 24/7 үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Арилжаа хийх “Брокерсмн” систем нь ямар нэгэн бүтээгдхүүний арилжааны бирж болон хөрөнгийн бирж дээр иргэн аж ахуйн нэгж оролцож арилжаа хийх, брокерийн болон банк санхүүгийн байгууллагуудын харилцагчын бүртгэл үүсгэх, хөтлөх, харилцагчийн харилцах дансны бүртгэл хөтлөх, үнэт цаасны төлбөр тооцоо хийх, хувьцааны бүртгэл хийх хөтлөх цогц систем юм.

Энэ систем нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Брокерийн үндсэн модуль - Brokers Core Module
2. Хувьцааны болон Валютын Арилжаа хийх платформ – Stock/FX Trading Platform
3. Харилцагчийн бүртгэл – Customers Registration
4. Харилцагч арилжаа хийсэн болон нээлттэй байгаа арилжаагаа харах, хийгдсэн хэлцэлүүдээ харах, түүнтэй холбоотой ашиг алдагдалаа харах, тооцоолох – Open Position & Profit / Loss & Historical Reports
5. Харилцагч өөрийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээнүүдээ хянах, дансаа зузаатгах болон мөнгө татаж авах – Customer Account, Money Deposit & Withdrawal
6. Арилжааны арын алба – Back Office
7. Арилжааны дундын алба – Middle Office
8. Хувьцааны үүсмэл хэрэгсэл арилжаа – CFD & Margin Trade
9. Санхүүгийн бүртгэл болон тайлан – Financial Module & Reports
10. Харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны банкинд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эскроу данс нээх хүсэлт илгээх - Open Escrow Account at Commercial Banks
11. Брокер харилцагчийн дансыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд дансыг нь үүсгэх- Create Customer Account at Mongolian Central Securities Depository

Системийн дээр дурьдсан хэсгүүдийг тайлбарлавал:

Брокерийн үндсэн модуль нь:

- нягтлан бодох бүртгэлийн ерөнхий дэвтэр;
- харилцагчийн бүртгэл хөтлөх модуль;
- арилжааны бүртгэл хөтлөх модуль;
- дансны бүртгэл хөтлөх модуль;
- төлбөр тооцооны бүртгэл зэрэг үндсэн модулаас бүрдэнэ.

Арилжаа хийх платформ нь вэб суурьтай бөгөөд харилцагч веб болон мобайл апп IOS, Андроид үйлдлийн систем ашиглан арилжаанд оролцох боломжийг олгоно.

Харилцагчийн бүртгэл нь системд бүртгэлтэй брокерийн компаниас сонголт хийн харилцагч болох хүсэлтийг алсын зайнаас бүртгүүлж дараах үйлчилгээг харилцагч хүлээн авна:

- Харилцагч брокерийн болон банк бус санхүүгийн байгууллагын компанид данс нээх хүсэлт илгээх;
- Арилжааны бүтээгдэхүүний үнэ ханш харах;

- Арилжааны бүтээгдхүүнтэй холбоотой зах зээлийн мэдээлэл авах;
- Харилцагч арилжааны бүтээгдхүүнтэй холбоотой хийсэн хэлцэлүүд, дансны гүйлгээнүүдээ харах;
- Харилцагчийн тухайн мөчид худалдан авсан эсхүл худалдсан арилжааны бүтээгдхүүний хэлцэлийг харах, зах зээлийн ханштай харьцуулсан ашиг, алдагдалаа харах;
- Дансны мөнгөн гүйлгээнүүдээ харах;
- Харилцагч дансаа зузаатгах, мөнгө татан авах үйлчилгээ авах.

Харилцагч арилжаа хийсэн болон нээлттэй байгаа арилжаагаа харах, хийгдсэн хэлцэлүүдээ харах, түүнтэй холбоотой ашиг алдагдалаа харах, тооцоолох нь харилцагч тухайн үед худалдан авсан болон худалдсан арилжааны бүтээгдхүүнээ тухайн мөчид зах зээлийн ханштай харьцуулж ашиг, алдагдалаа харах, өмнө нь хийсэн арилжааны хэлцэлүүд тэдгээрээс бий болсон ашиг алдагдалаа харах боломжийг олгоно.

Харилцагч өөрийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээнүүдээ хянах, дансаа зузаатгах болон мөнгө татаж авах нь харилцагчийн мөнгөний үлдэгдэл хэзээ дансандаа мөнгө хийж татаж байсан гүйлгээнүүд, одоо байгаа мөнгөний үлдэгдэлээ харах, дансанаасаа хэрхэн мөнгө зузаатгах, татаж авах зэргийг харуулна.

Арилжааны арын алба нь брокерийн компанийн харилцагчидийн хийсэн арилжааны хэлцэлүүдийг баталгаажуулах, хийгдсэн арилжааны гүйлгээнүүдийг автоматаар хийнэ.

Арилжааны дундын алба нь брокерийн компанийн харилцагчидийн зээлжих зэрэглэл Credit Rating рейтингийг тогтоох, тэдгээрт VAR-Value at Risk арга ашиглах, харилцагчдадын арилжаанд стоп лосс, лимит зэргийг тооцоолно.

Хувьцааны үүсмэл хэрэгсэл арилжаа нь харилцагчдад үүсмэл хэрэгсэл /жиш хувьцаа г.мэт/ болох бүтээгдэхүүнүүдийг зээлээр олгож арилжаанд оролцох боломжийг олгоно.

Санхүүгийн бүртгэл болон тайлан нь брокерийн компанийн санхүүгийн тайлан, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан зэргийг тухайн өндөрлөх үед гаргаж холбогдох тайлан мэдээлэлийг боловсруулж гаргана.

Харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны банкинд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эскроу данс нээх хүсэлт илгээх нь зарим бүтээгдэхүүн тухайлбал үнэт цаасны компанийн брокерийн болон банк санхүүгийн байгууллагын харилцагчидийн дансыг арилжааны банкуудад хүсэлт хэлбэрээр илгээн нээх боломжийг олгоно.

Брокер, банк санхүүгийн байгууллагын харилцагчийн дансыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд дансыг нь үүсгэх нь зарим бүтээгдхүүний арилжаа хийдэг брокерийн компани турхайлбал үнэт цаасны брокерийн компанийн харилцагчидийн дансыг үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төвд шууд илгээх боломжийг олгоно.

Банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн систем

Энэ систем нь Банк бус санхүүгийн байгууллагын суурь бүртгэлийн ерөнхий дэвтэр, харилцагчийн бүртгэл хөтлөх, тайлан мэдээ, санхүүгийн тайлан гаргах, он лайн горимд зээл олгох зэрэг бусад хэрэгцээт модулыг агуулсан систем нь дараах шийдлүүдтэй байна.

Бусад хөгжүүлж буй болон хөгжүүлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүнүүд

Зочид буудлын бүртгэлийн систем

Захиалга хүлээн авах, бүртгэх процестой, буудлын өрөө, үйлчилгээний төрлүүдийг ангилсан үндсэн үнэ болон хямдралтай үнийн зохицуулалт хийх, захиалгын төлөвлөгөө, хуваарийг хүссэнээрээ зохион байгуулах боломжтой үр дүн, тайлан болон анализ шинжилгээ хийх боломжтой систем юм.

Хямд систем

Хэрэглэгч өөрийн хайж буй бүтээгдэхүүний хамгийн хямдыг олох боломжтой бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарыг шалгах боломжтой систем.

Системүүдийг хөгжүүлж дуусахаар төлөвлөж байгаа хугацаа:

Технологи

Бүтээгдэхүүн болох програм хангамжууд нь технологийн дараах шийдлүүдтэй байна. Үүнд:

Хөгжүүлэлтийн орчин

Cloud орчинд олон байгууллага ашиглах боломжтойгоор хөгжүүлнэ.

Өгөгдлийн сангийн хөгжүүлэлт

Өгөгдлийн сангийн хөгжүүлэлтэнд Oracle 18c ашиглаж, нэг дор олон хэрэглэгч хандах боломжтойгоор кодчилж, тохиргоог оновчтой байдлаар шийдвэрлэнэ.

18^c ORACLE[®]
Database

RESTfull сервисийн хөгжүүлэлт

№	Хөгжүүлж буй систем	Зах зээлд нэвтрүүлэх хугацаа		
1	Үнэт цаасны арилжааны платформ	2022-IY	Үнэт цаасны ко	 Oracle Rest Data Services
2	Банк бус санхүүгийн байгууллагын систем	2022-IY	Эйс ассошиэйтс ББСБ-д	
3	Зээлийн оноо өгөх & Онлайн байдлаар зээл олгох модул	2022-II	Эйс ассошиэйтс	
4	Гадаад валютын арилжааны платформ	2022-IY	Эрдэнэс капитал маркетс ХХК-д	
5	Үнэт металлын арилжааны платформ	2022-IY	Эрдэнэс коммодитийс трейдинг ХХК-д	
6	Үл хөдлөх хөрөнгө зуучлалын систем	2023-IY	Эрдэнэс рийл эстэйт ХХК-д	

Oracle –ийн хамгийн сүүлийн үеийн технологи болох **Oracle RESTfull Data Service**-ийн ашиглан санхүүгийн системд ашиглах бүртгэлгийн сервисүүд болон бусад системээс хандах API-ийг хөгжүүлнэ.

ORDS нь хэрэглэгчийн хандах нууцлалыг **OAuth2.0** –ийн дагуу хангаж ажилладаг.

Веб хөгжүүлэлт

Веб хөгжүүлэлтийг томоохон компаниуд ашиглаж буй, өндөр хурдтай уян хатан, нэмэлт хөгжүүлэлтийг хялбар хийх боломжтой **React JS** фрэймворк ашиглан хөгжүүлнэ.

Oracle Apex 21.2 – Томоохон хэмжээний мэдээллийн системийг хамгийн үр ашигтайгаар, нууцлалт аюулгүй байдлыг бүрэн хангасан байдлаар бүтээх технологийг ашигласан. Ингэснээр уг системийг харьцангуй богино хугацаанд хөгжүүлсэн ба цаашдийн нэмэлт хөгжүүлэлт, засварлалтыг хялбар гүйцэтгэнэ.

Oracle ORDS 21.4 – Гадаад системүүдтэй сүүлийн үеийн RESTful стандартын дагуу холбогдох API боловсруулсан.

Oracle Database 21 – Мэдээлэлд хоцрогдолгүйгээр хандах, аюулгүй хадгалах болон тасралтгүй ажиллагааг хангана.



XBRL – Олон улсын нээлттэй стандартыг хэрэгжүүлж ямар ч орны системтэй холбогдож ажиллах боломж олгосон.

PWA – Progressive Web Apps технологийг ашиглаж программыг Windows, MacOS, Linux, Android үйлдлийн системүүд дээр суулгаж ашиглах боломжтой болгосон. Мөн шаардлагатай мэдээллийг Push Notification байдлаар цаг алдалгүй илгээнэ.



Компанийн удирдлагын мэдээлэл

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд дараах схемийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. ТУЗ нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, гүйцэтгэх удирдлагыг сонгох, ажилд нь хяналт тавих зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээс гадна Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах зээг ажлуудыг зохион байгуулдаг. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй ба ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгодог байна.

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон байна.

Хүснэгт 1. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүд

Овог, нэр	Албан тушаал
1 Ц.Хүдэрмөнх	ТУЗ-ийн ердийн гишүүн
2 Т.Золбоо	ТУЗ-ийн ердийн гишүүн
3 Ц.Хишигбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн
4 Г.Аззаяа	ТУЗ-ийн ердийн гишүүн
5 Э.Цэндсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн
6 Б.Батхүү	ТУЗ-ийн ердийн гишүүн
7 Б.Энхзориг	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8 С.Энхжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9 П.Нарантунгалаг	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хүснэгт 2. ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага

Нэр	Боловсрол	Ажлын туршлага
Ердийн гишүүд:		
Ц.Хүдэрмөнх	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр төгссөн.	Хас банкинд систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээчээр 2009-2016 онд, Бодь даатгал ХХК-д системийн шинжээч, цахим банкны хэлтэсийн захиралаар 2016-2018 онд, ISOL ХХК-д мэдээлэлийн технологийн хэлтсийн захиралаар ажиллаж байсан. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна.
Т.Золбоо	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр, 2012 онд магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.	Каракас зураг ХХК-д програмистаар 2006-2007, МИАТ ХК-д програмистаар 2007-2009, Алтан тариа ХК-д системийн шинжээчээр 2009-2010 онуудад ажиллаж байсан. ШУТИС-Мэдээлэл холбооны технологийн сургуульд 2010 оноос хойш өнөөдрийг хүртэл багшаар ажиллаж байна. Япон улсад болсон

		олон улсын Прокон програм хангамжийн тэмцээний 2005 оны түрүү байрын, Програмчлалын дэлхийн аваргын АСМ2005 тэмцээний 2005 оны тусгай байрын шагналтай.
Ц.Хишигбаатар	Ховд аймгийн 10-н жилийг 1989 онд бүрэн дунд боловсрол төгссөн.	Хувиараа ажиллаж байна.
Г.Аззаяа	Нийслэлийн Оюуны ундраа цогцолбор сургуулийг 1998 онд бүрэн бус дунд боловсрол төгссөн.	Союз номин ХХК-д 2006 оноос хойш харуулын захирлаар ажиллаж байна.
Э.Цэндсүрэн	Япон улсын Шинсү Их Сургуулийг 2009 онд барилга, дэд бүтцийн инженерийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.	Говь ХК-д үйлдвэр хариуцсан ахлах менежерээр 2009-2011, Бридж групп-д Технологийн инженерээр 2011-2011, Таван богд трейд ХХК-д брэнд менежер, төслийн менежерээр 2011-2015, Монос Улаанбаатар ХХК-д 2015-2017 онуудад төслийн менежерээр ажиллаж байсан. Шинэ Монгол Коосэн технологийн коллеж-д 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
Б.Батхүү	Санхүү эдийн засгийн дээд сургуулийг банк санхүүгийн бакалавр зэрэгтэйгээр 1997 онд төгссөн.	ХХБ-д эдийн засагч, ахлах эдийн засагч, Үйл ажиллагаа харуцсан захирал 1996-2004, УБХБ-д Хөрөнгө зохицуулатын газрын захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирал 2004-2007, Капитрон банкинд Гүйцэтгэх захирлын зөвлөх, ҮАБЗАА-нд банк санхүү хариуцсан референт 2009-2011 онуудад ажиллаж байсан. Экспонэйншл фанд менежмент ҮЦК ХХК-д 2011 оноос хойш өнөөдрийг хүртэл Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
ТУЗ-ийн хараат бус гишүүд:		
П.Нарантунгалаг	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр, ШУТИС-КТМС-	Интерактив ХХК-д програмист мэргэжлээр 2007-2012 онд ажиллаж байсан. Хас банкинд 2012 оноос

	ийг 2013 онд магистраар тус тус төгссөн.	хойш өнөөдрийг хүртэл систем аналитаар ажиллаж байна.
Б.Энхзориг	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг 2013 онд англи хэлний орчуулагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр, СЭЗДС-ийг 2016 онд Бизнесийн удирдлагын магистраар тус тус төгссөн.	Хасабэ интернэйшнл ХХК-д захиргааны ажилтан 2006-2007 онд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн нарийн бичгийн даргаар 2008-2011 онд, Швейцарын хөгжлийн агентлаг/Монголын хөгжил судлал төвд төслийн менежерээр 2011-2014 онуудад ажиллаж байсан. СЭЗДС-д 2014 оноос хойш өнөөдрийг хүртэл сургалтын менежер багшаар ажиллаж байна.
С.Энхжаргал	УБИС-ийг 2002 онд дүрслэх урлаг дизайны бакалавр зэрэгтэйгээр төгссөн.	Говь ХК-д дизайнераар 2003, Эдмон ХХК-д дизайнераар 2004, Мон хорус интернэйшнл ХХК-д 2008-2019 гэрээт дизайнераар ажиллаж байсан. Авто ойл ХХК-д гэрээт дизайнераар 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

2011 оноос хэрэгжиж эхэлсэн “Компанийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар хувьцаат компанийн хувьд ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулахаар заасан. Компанийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь ТУЗ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн №ТУЗТ 02/2020 тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүдийг шинэчлэн томилсон байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт 3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

Цалин, урамшууллын хороо	1. Т.Золбоо- /Хорооны дарга/ 2. С.Энхжаргал 3. Б.Энхзориг
Аудитын хороо	1. П.Нарантунгалаг- /Хорооны дарга/ 2. С.Энхжаргал 3. Э.Цэндсүрэн
Нэр дэвшүүлэх хороо	1. Б.Энхзориг- /Хорооны дарга/ 2. Ц.Хүдэрмөнх 3. П.Нарантунгалаг

Гүйцэтгэх захирал:

Хүснэгт 4. Гүйцэтгэх захирал, алба хариуцсан захирлуудын боловсрол, ажлын туршлага

Нэр	Боловсрол	Ажлын туршлага
Ц.Хүдэрмөнх Гүйцэтгэх захирал	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр төгссөн.	Хас банкинд систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээчээр 2009-2016 онд, Бодь даатгал ХХК-д системийн шинжээч, цахим банкны хэлтэсийн захиралаар 2016-2018 онд, ISOL ХХК-д мэдээлэлийн технологийн хэлтсийн захиралаар ажиллаж байсан. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар 2019 оноос, 2020 оноос хойш Эрдэнэс сольюшинс ХК-ийн Гүйцэтгэх захиралаар өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

4. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтаны цалин урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 1 бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 ширхэг бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн эцсийн байдлаар нийт 241 хувьцаа эзэмшигчтэй байна.

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн ТУЗ-ын дарга Т. Золбоо, Гүйцэтгэх захирал бөгөөд ТУЗ-ын ердийн гишүүн Ц.Хүдэрмөнх, ТУЗ-ын ердийн гишүүн Б.Батхүү нарын нийт гаргасан энгийн хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл:



Компанийн Гүйцэтгэх захирал Ц. Хүдэрмөнх нь “Эрдэнэс сольюшинс” ХХК ажиллаж байхдаа сарын 3.5 сая төгрөгийн цалин авч байсан бөгөөд компанийг нэгтгэсэний дараа энэ цалингийн хэмжээг хэвээр үргэлжлүүлсэн. Компанийн ТУЗ-ын 2020 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор Ц. Хүдэрмөнхийг компанийн Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд, ТУЗ-ын 2020 оны 07-р сарын 07-ны өдрийн ТУЗТ 09/2020 тоот тогтоолоор дээр дурьдсан цалинг баталгаажуулсан тогтоол гаргасан.

Компанийн бусад ТУЗ-ын гишүүд болон эрх бүхий албан тушаалтанууд одоогоор ямар нэгэн цалин, урамшуулал аваагүй болно.

5. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компанийн талаарх мэдээлэл, хяналтын багц, ҮЦЗЗТХ-ийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээдүүдийнх нь тухай мэдээлэл

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 1 бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 ширхэг бөгөөд 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэх өдрийн байдлаар нийт 191 хувьцаа эзэмшигчтэй байна.

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээлэл:



“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хувьцаа эзэмшигч Т. Дөлгөөн нь “Субашид тек” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Т. Золбоогийн төрсөн дүү бөгөөд эдгээр нь нэгдмэл сонирхолтой этгээдүүд юм.

“Субашид тек” ХХК-ийн 33.33%-ийг эзэмшигч Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Батхүүгийн төрсөн ээж нь Г. Дулмаа нь компанийн гаргасан энгийн хувьцааны 5.80%-ийг эзэмшигдэг бөгөөд компанийн 0.9 хувийг эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц. Хишигжаргал нь түүний хүргэн байна.

Компанийн энгийн хувьцааны 5 хувиас дээш хувьцаа эзэмшигч эдгээр 5 иргэн нь компанийн нийт энгийн хувьцааны 87.5%-ийг эзэмшдэг болно.

Хүснэгт 5. “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн нийт гаргасан хувьцааг эзэмшигч Субашид тек ХХК

“Субашид тек” ХХК-ийн товч танилцуулга

“Субашид тек” ХХК нь програм хангамжийн, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа чиглэлээр 2018 оны 04-р сарын 06-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Одоогоор зөвхөн хөрөнгө оруулалтын буюу “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн хувьцаа эзэмшин ажиллаж байна. компанийн энгийн хувьцааны 33.33%-ийг иргэн Ц. Хүдэрмөнх, Т.Золбоо, Б.Батхүү нар эзэмшдэг байна.

6. Компанийн сүүлийн 1 жилийн хугацаанд бусадтай байгуулсан гэрээ хэлцэл, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэлийн талаар

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн сүүлийн

№	Нэр	Регистр	Хаяг	Хувьцааны тоо, хувь ЭЗЭМШИЛ
1	“Субашид тек” ХХК	6295541	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффис, 4-р давхар	65.00%

3 жил дотор буюу 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгосон өдрийн хооронд бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд КТХ-ийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

(i) Их хэмжээний хэлцэл

КТХ-ийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалт, 87.1.2 дахь заалт зэрэгт тус тус зааснаар “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/ болон компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор хуульчилсан.

“Эрдэнэ сольюшинс” ХК-ийн 2021 нийт 33 гэрээ байгуулсан. **Нэгтгэвэл Компани нь сүүлийн 1 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй.**

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компани 2021 онд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлүүдийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй 7 ширхэг гэрээ хийсэн. Үүнээс 4 ширхэг сонирхолын зөрчилтэй гэрээ хүчин төгөлдөр байгаа болно.

Гэрээг КТХ-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах журмын дагуу баталсан болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд КТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт “сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана” гэж заасан байна. Сонирхолын зөрчилтэй гэрээг ТҮЗ-ийн хараат бус гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэсэн.

Компанийн 2021 онд хийсэн гэрээний жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

7. Компанийн ноогдол ашгийн талаар

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр:

Компанийн санхүүгийн тайлан өнгөрсөн жил компани нэгтгэхтэй холбоотойгоор болон шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж байгаатай холбоотойгоор орлогын тайлан 161,8 сая төгрөгийн алдагдалтай гарсан. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Компанийн ТУЗ-ын 2016 оны 05-р сарын 12-ны өдрийн хурлын ТУЗТ 03/2016 тоот тогтоолын 7-р хавсралтаар батлагдсан “Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэл тарааж олгох журам”-ын 1-р зүйлийн 1.1.2.Компанийн ногдол ашгийн ойрын ба хэтийн бодлого, хуваарилалт нь ирээдүйд компанид хөрөнгө оруулалт татахуйц байх, 1.1.3.Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ нь компанийн тухайн жилийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур биш байх, 1.1.4.Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилах зарчим баримтлах, 1.1.5.Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээг (тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд) бууруулахгүй байх бодлого баримтлах нөхцөлүүдийг хангасан нөхцөл байхгүй ТУЗ-ын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын №ТУЗТ 01/2022 тоот тогтоолоор

“1.Компани 2021 оны ноогдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.” Гэсэн шийдвэрийг гаргасан байна.

8. Охин компаниудын тухай

Эрдэнэс капитал маркетс ХХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2019.12.09
Регистерийн дугаар:	6504795
Хувь эзэмшил:	100%

Үйл ажиллагааны чиглэл

Монгол Улсын Их Хуралд “Валютын зохицуулалтын тухай хууль” өргөн баригдаж энэ 2021 оны хаврын чуулганаар хэлэлцэгдэхээр төлөвлөгдөж байгаа бөгөөд өргөн баригдсан хуульд аж ахуйн нэгжүүд валютын бирж байгуулах тухай заалт орсон.

Валютын арилжааны програм хангамж, платформыг хөгжүүлж байгаа бөгөөд 2023 оны 1-р улиралд ажилуулахаар төлөвлөж байна.

Эрдэнэс агро энд ресортс ХХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2020.03.16
Регистерийн дугаар:	6544991
Хувь эзэмшил:	100%

Үйл ажиллагааны чиглэл

Сүүлийн үед хаа-г технологижуулах үйл явц олон улсад идэвхжиж байгаа бөгөөд үхрийн махны чиглэлийн аж ахуй байгуулж түүнийг технологижуулах ялангуяа үхрийн хээлтүүлэг, хариулга, гэжээлд чип, дрон, тусгай програм хангамжийг ашиглах болсон. Ялангуяа Израйл, Франц улсын технологийг нутагшуулах экспортод мах гаргах, хаа-г дагасан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор байгуулсан. Төв болон Сэлэнгэ аймагт газрын судалгаа хийж байгаа 2023 оноос үйл ажиллагааг идэвхжүүлэхээр төлөвлөж байна.

Эрдэнэс рийл эстэйт ХХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2020.03.26
Регистерийн дугаар:	6548989
Хувь эзэмшил:	100%
Тусгай зөвшөөрөл:	Үл хөдлөх хөрөнгө зуучлал

Үйл ажиллагааны чиглэл

“Хар хорум пропертийс” ХК нь үл хөдлөх хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд ТУЗ-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗТ 06/2020 тоот тогтоолоор “Эрдэнэс рийс эстэйт” ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагааг тусгаарласан. СЗХ-ны 2020 оны тоот ТЗ 601/54 тогтоолоор үл хөдлөх хөрөнгийн зуучлалын тусгай зөвшөөрөл авсан.

Үл хөдлөх хөрөнгө бүртгэлийн програм хангамж, платформыг хөгжүүлж байгаа бөгөөд 2023 оны 1-р улирлаас эхлэн ажилуулахаар төлөвлөж байна.

9. Худалдан авсан охин компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Эйс ассошиэйтс ББСБ

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2012.11.19
Регистерийн дугаар:	5651077
Хувь эзэмшил:	85%
Тусгай зөвшөөрөл:	Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа

Үйл ажиллагааны чиглэл

Компани банк бус санхүүгийн байгууллагын үндсэн модул, зээлийн үйл ажиллагааны зээлжих зэрэглэлийн системийг хөгжүүлж байгаа бөгөөд зээлийн үйл ажиллагааг онлайн байдлаар бичил зээл олгоно. ББСБ дах хувь эзэмшлээ 2021 оны 3-р улирал гэхэд 95%-д хүргэхээр төлөвлөж байна.

Програм хангамж 2022 оны 1-р улиралд хөгжүүлж дуусган, 2-р улирлаас эхлэн ажилуулахаар төлөвлөж байна.

10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц болон хуралдаанаар 2021 онд хэлэлцсэн асуудлууд

Төлөөлөн удирдах зөвлөл 2021 онд 11 удаа хуралдсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд 2021 онд хуралдаа 100 хувь ирцтэйгээр оролцсон бөгөөд өвчтэй, чөлөөтэй, тасалсан гишүүд байхгүй.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд болон их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлэлцэх асуудалд санал өгсөн байдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны хуралдаанаар нийт 51 асуудлаар санал хураасан байна. Үүнээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонирхолын зөрчилтэй 11 хэлцэлд санал өгөнөөс, 100 хувь зөвшөөрсөн санал өгсөн бөгөөд их хэмжээний хэлцэл хийх талаар хуралдаагүй байна.

Хавсралт 2-оос Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны хуралдааны ирц болон хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд, гишүүдийн санал өгсөн байдалыг харна уу.

ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХАЛДИН ХЭМДЭГЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ДАГААЛД ХАРИУТГЭЙ ЖЭГЭЭНИЙ ГЭ																Тайлбар: Байгуулгын өртөг: 31-Оны-2021																																																																							
№	Гэрээний үндэсний нэр	Төлбөргүй хугацаа	Хугацаа			Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл			Нэгж үнийн хэмжээ	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл																																																																								
			АН	МН	НХ				Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл																																																																												
1	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	СУБАНД ТХС ХХК	1	3		Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл																																																																								
2	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ПН КСҮЭ 90 МОГОСОНА АУДИТ	1			Аудитын өртөг	2021 оны өртөг	5-Ан-2021	5-Ан-2021	5-Ан-2021	30-Ан-2021	4	1,000,000.00	1198	1198	100.00%																																																																							
3	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	БАЛСҮРЭН	2			Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	7-Ан-2021	7-Ан-2021	11-Ан-2021	3	4,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
4	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ХНН	2			Төлбөргүй зээл	Төлбөргүй зээл	15-Ан-2021	15-Ан-2021	11-Ан-2021	3	3,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
5	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	МОН УХД	1			Сүрьеэ гэрээний өртөг	Сүрьеэ гэрээний өртөг	15-Ан-2021	15-Ан-2021	11-Ан-2021	10	200,000.00	1198	1198	100.00%																																																																								
6	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	К.БАТДҮ	2	4	4	Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	20-Ан-2021	20-Ан-2021	20-Ан-2021	0	400,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
7	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	МНПҮЭСЭГ СӨХӨӨРӨНГӨ МОНГОЛ УХД	1			Ашиггүй өртөг	Ашиггүй өртөг	21-Ан-2021	21-Ан-2021	27-Ан-2021	1	1,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
8	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	СУБАНД ТХС ХХК	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	24-Ан-2021	24-Ан-2021	24-Ан-2021	0		1198	1198	100.00%																																																																								
9	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	МНПҮЭСЭГ СӨХӨӨРӨНГӨ МОНГОЛ УХД С.Х.АЙДИ ТХС ХХК	1			Борлогчийн өртөг	Борлогчийн өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	05-Ан-2022	12		1198	1198	100.00%																																																																								
10	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ХХК	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	130		1198	1198	100.00%																																																																								
11	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ХХК	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	130		1198	1198	100.00%																																																																								
12	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ХХК	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	130		1198	1198	100.00%																																																																								
13	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ЦЭДРАГСАКАБАН	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	12	5	5,000,000.00	1198	1198	100.00%																																																																							
14	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	A. ГАНБОЛД	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	12	30,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
15	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	LEE SOJUN	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	12	5	5,000,000.00	1198	1198	100.00%																																																																							
16	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	БАРЦУКЧИ	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	28-Ан-2021	28-Ан-2021	28-Ан-2021	12	4,500,000.00	1198	1198	100.00%																																																																								
17	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	БАТ-ЭРДЭН	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	2-Ан-2022	2-Ан-2022	2-Ан-2022	12	271,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
18	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	KUMAR DUSANDEK	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	05-Ан-2022	05-Ан-2022	05-Ан-2022	4	11,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
19	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	МНПҮЭСЭГ СӨХӨӨРӨНГӨ МОНГОЛ УХД	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	24-Ан-2021	24-Ан-2021	24-Ан-2021	12	50,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
20	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	Ж.ЖИЖИГИЙН	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	2-Ан-2022	2-Ан-2022	2-Ан-2022	09		1198	1198	100.00%																																																																								
21	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ЭРДЕНЭС ОЙНД ХӨНӨӨ МОНГОЛ УХД	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	0-Ан-2022	0-Ан-2022	2-Ан-2022	06		1198	1198	100.00%																																																																								
22	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ОНУН YOUNG	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	16-Ан-2021	27-Ан-2021	27-Ан-2021	12	100,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
23	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	S. OYUNBAT	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	15-Ан-2021	15-Ан-2021	15-Ан-2021	12	50,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
24	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	НУДЭВЧД ХХК	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	20-Ан-2021	20-Ан-2021	05-Ан-2022	3	80,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
25	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ТОРХОЛД	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	20-Ан-2021	20-Ан-2021	06-Ан-2022	3	60,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
26	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	МОНГОЛ УХД	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	1-Ан-2022	1-Ан-2022	1-Ан-2022	12	200,000.00	1198	1198	100.00%																																																																								
27	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	Ж.ЖИЖИГИЙН БАТБАЯР ЖУДПАРТИС ЖИХАМОНГОЛ ГОВЬ ТРАНС	1			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	05-Ан-2022	05-Ан-2022	05-Ан-2022	0	20,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
28	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	КАТДҮ	2	4	4	Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	15-Ан-2021	15-Ан-2021	15-Ан-2021	0	201,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
29	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	КАТ-ЭРДЭН	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	05-Ан-2022	05-Ан-2022	02-Ан-2022	7	1,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
30	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	БАТ ХӨНӨӨМ ХХК, КАТ-ЭРДЭН	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	05-Ан-2022	05-Ан-2022	05-Ан-2022	2	30,202,710.00	1198	1198	100.00%																																																																								
31	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ТАВАНОГДКАНГАЛ УХД	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	23-Ан-2021	23-Ан-2021	24-Ан-2022	12		1198	1198	100.00%																																																																								
32	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ӨНӨГӨНДИЙН БАТБАЯР ЖУДПАРТИС ХӨНӨӨМ	1	4		Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	06-Ан-2021	06-Ан-2021	20-Ан-2022	2	22,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
33	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	ПН КСҮЭ 90 МОГОСОНА АУДИТ	1			Аудитын өртөг	2021 оны өртөг	27-Ан-2021	27-Ан-2021	06-Ан-2022	1	1,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
34	ЭРДЕНЭС СОЛБИМОНИС ХК	И.ЦЭСЭГ	2			Хөдөлгөөний өртөг	Хөдөлгөөний өртөг	27-Ан-2022	27-Ан-2022	1-Ан-2022	8	30,000,000.00	1198	1198	100.00%																																																																								
													1,051,401,021.22																																																																										
<table border="1"> <thead> <tr> <th>Гэрээний үндэсний нэр</th> <th>Нэгж</th> <th>Хэрэглэлийн төрөл</th> <th>Хэрэглэлийн төрөл</th> <th>Хэрэглэлийн төрөл</th> <th>Хэрэглэлийн төрөл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1. Өртөг</td> <td>2</td> <td>10</td> <td>10</td> <td>10</td> <td>10</td> </tr> <tr> <td>2. Өртөг</td> <td>2</td> <td>10</td> <td>10</td> <td>10</td> <td>10</td> </tr> <tr> <td>3. Өртөг</td> <td>3</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>4. Өртөг</td> <td>4</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>5. Өртөг</td> <td>5</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>6. Өртөг</td> <td>6</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>7. Өртөг</td> <td>7</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>8. Өртөг</td> <td>8</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>9. Өртөг</td> <td>9</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>10. Өртөг</td> <td>10</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>11. Өртөг</td> <td>11</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> </tbody> </table>																Гэрээний үндэсний нэр	Нэгж	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	1. Өртөг	2	10	10	10	10	2. Өртөг	2	10	10	10	10	3. Өртөг	3	0	0	0	0	4. Өртөг	4	0	0	0	0	5. Өртөг	5	0	0	0	0	6. Өртөг	6	0	0	0	0	7. Өртөг	7	0	0	0	0	8. Өртөг	8	0	0	0	0	9. Өртөг	9	0	0	0	0	10. Өртөг	10	0	0	0	0	11. Өртөг	11	0	0	0	0
Гэрээний үндэсний нэр	Нэгж	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл	Хэрэглэлийн төрөл																																																																																		
1. Өртөг	2	10	10	10	10																																																																																		
2. Өртөг	2	10	10	10	10																																																																																		
3. Өртөг	3	0	0	0	0																																																																																		
4. Өртөг	4	0	0	0	0																																																																																		
5. Өртөг	5	0	0	0	0																																																																																		
6. Өртөг	6	0	0	0	0																																																																																		
7. Өртөг	7	0	0	0	0																																																																																		
8. Өртөг	8	0	0	0	0																																																																																		
9. Өртөг	9	0	0	0	0																																																																																		
10. Өртөг	10	0	0	0	0																																																																																		
11. Өртөг	11	0	0	0	0																																																																																		

Компанийн хаяг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2
дугаар хороо, 40 50 мянгат /15171/ Бакула
ринбучийн гудамж 30 байр, 10-р давхар
(976)-11-99037119

Холбоо барих утас

www.erdenes.solutions

Вэб сайт

Info@erdenes.solutions

И-мэйл